



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/403

Зуунмод

“Цусны даралтаа тогтмол хянаж хэвшигчгээ”
аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2, “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын нас баралтын дийлэнх хувийг эзэлж буй тархины харвалт, зүрхний шигдээс өвчин нь цусны даралт ихсэлттэй холбоотой байгаа тул дулааны улиралд иргэдийг хэт халалтаас үүдэлтэй артерийн даралт ихсэлт, зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Цусны даралтаа тогтмол хянаж хэвшигчгээ” аянг аймгийн хэмжээнд 2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаатай зохион байгуулсугай.

2. Аяны удирдамж, төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, суурин даралтын аппарат байрлуулж, байгууллагын албан хаагчид, иргэдийн артерийн даралтаа хянах нөхцөлийг бүрдүүлж ажиллах төрийн болон үйлчилгээний байгууллагын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Иргэдэд өдөр тутмын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд холбогдох зардлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэн, үйлчилгээ үзүүлэх цэгүүдэд суурин даралтын аппаратыг даралт зөв хэмжих зөвлөмжийн хамт байршуулан, ажилтан албан хаагчид, иргэдийг өөрсдөө тогтмол даралтаа хянах боломж бүрдүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, агентлаг, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр ханган, тайлан мэдээг сар тутам нэгтгэн, дүгнэлт хийж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар /С.Мөнхтуяа/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2019
оны 07 дугаар сарын 02-ны
өдрийн А/УОЗ дугаар
захирамжийн хавсралт

“ЦУСНЫ ДАРалТАА ТОГТМОЛ ХЯНАЖ ХЭВШИЦГЭЭЭ” АЯНЫ УДИРДАМЖ

Танилцуулга: Цусны даралт ихсэх өвчин нь хамгийн түгээмэл тархалттай халдварт бус өвчин юм. Дэлхий дээр цусны даралт ихсэх өвчинтэй 1,5 тэрбум хүн амьдардаг. Манай улсад насанд хүрсэн гурван хүний нэг нь цусны даралт ихсэх өвчинтэй байна. Цусны даралт ихсэх өвчин нь зүрхний шигдээс, тархины цус харвалт, зүрхний архаг дутагдал, чихрийн шижин зэрэг эмгэгүүдийн эрсдэлт хүчин зүйл болдог.

Монгол улсын нийт нас баралтын 34% нь зүрх судасны өвчний шалтгаантай бөгөөд тархины харвалт, зүрхний шигдээсээр нас барсан тохиолдлын 50 хувь нь даралт ихсэлттэй холбоотой нь судалгаагаар тогтоогдсон. Цусны даралт ихсэх өвчний эмчилгээнд амьдралын зөв хэвшлийг төлөвшүүлэх, эмэн эмчилгээ чухал бөгөөд эмчилгээний үр дүнг хянахад цусны даралтаа тогтмол хэмжих арга зайлшгүй чухал болж байна

Зорилго: Цусны даралтаа тогтмол хянаж хэвшүүлэх замаар халдварт бус өвчний хүндрэлээс сэргийлэхэд оршино.

Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл:

1. Иргэдэд артерийн гипертензи, цус харвалтаас сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулах
2. Цусны даралтаа хэрхэн зөв хэмжих талаар зөвлөмж гаргаж, албан байгууллага, ААН-д тараах
3. Албан байгууллага, ААН-ийн ажилтан албан хаагчдын цусны даралтаа тогтмол хянах орчин нөхцлийг бүрдүүлэх, байгууллагын бүх ажилчдыг цусны даралтаа тогтмол хянаж хэвшихийг уриалах
4. Өрх, сумын ЭМТ-үүд Артерийн гипертензи, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэх

Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2019 оны 07 дугаар сарын 01

Хамрах хүрээ: Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон ААН, байгууллага, иргэд

Хэрэгжүүлэх байгууллага: Аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын Төв ОНХХ

Хамтран хэрэгжүүлэх: АНЭ, СЭМТ, ӨЭМТ

Гарах үр дүн: Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа артерийн даралт ихсэлт, цус харвалт, зүрхний шигдээс, чихрийн шижин зэрэг ХБӨ-ийг эрт илрүүлэн эмчлэх нөхцөл бүрдсэнээр ХБӨ-ий шалтгаант нас баралт, өвчлөлийн тоо буурна.

**“ЦУСНЫ ДАРАЛТАА ТОГТМОЛ ХЯНАЖ ХЭВШИЦГЭЭЕ”
АЯНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх
1	“Цусны даралтаа тогтмол хянаж хэвшицгээе” аяны удирдамж, төлөвлөгөө, төсвийг батлуулах	VI/28	ЭМГ	ЗДТГ
2	ААН, албан байгууллагад цусны даралт тогтмол хянах орчин нөхцлийг бүрдүүлж, албан хаагчдыг халдварт бус өвчлөлөөс сэргийлэх тухай шийдвэр гаргуулах	VII/01	ЭМГ	ЗДТГ
3	Цусны даралт ихсэлт, түүний эрсдэлт хүчин зүйлийн тухай эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт иргэдэд явуулах	VII/01- X/01	АНЭ, Сум, өрхийн ЭМТ	ААН, албан байгууллагууд
4	Зорилтот бүлгийн иргэдэд цусны даралт ихсэлтийн эрт илрүүлгийн үзлэг оношилгоо хийх	VII/01- X/01	Сум, өрхийн ЭМТ	ААН, албан байгууллагууд
5	Сум, багийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалт зохион байгуулж, цусны даралт ихсэлтийг эрт илрүүлэх, оношлох, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх	VIII/25- IX/01	ЭМГ	АНЭ, Сум, өрхийн ЭМТ
6	Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэх тухай болон цусны даралт зөв хэмжих талаар зөвлөмж гаргаж ААН, албан байгууллагуудад хүргэх	VII/01- VII/05	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ
7	Цусны даралт ихсэх өвчнөөс сэргийлэх тухай болон цусны даралт зөв хэмжих талаар зөвлөмжийг орон нутгийн телевизээр явуулах	VII/01- X/01	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ, TBS телевиз
8	Байгууллагуудын тайлан мэдээг нэгтгэх, явцын үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмж хүргүүлэх	Сар бүр	ЭМГ	Сум, өрхийн ЭМТ

Аймгийн Засаг даргын 2019 оны
07 дугаар сарын 02 ны өдрийн
А/МЗ дугаар захирамжийн
хавсралт

Суурин даралтын аппарат байрлуулж иргэд, ажилтан албан хаагчдын артерийн даралтаа хянах нөхцлийг бүрдүүлэх байгууллагын нэрс

№	Байгууллагын нэр	Илтгэх хуудас ирүүлэх өдөр	Илтгэх хуудас ирүүлэх хаяг
1	Аймгийн ЗДТГ	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
2	Зуунмод сумын ЗДТГ	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
3	МХГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
4	БСУГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
5	ГБХЗХГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
6	Татварын хэлтэс	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
7	НДХэлтэс	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
8	МЦХолбоо ХХК	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
9	МТТеатр	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
10	Музей	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
11	Нийтийн номын сан	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
12	УБХэлтэс	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
13	Төв чандмань ДЭХГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
14	ХХААГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
15	БТСГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
16	ОБГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
17	Авто тээврийн төв	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
18	ХХҮГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
19	ГХБХБГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
20	УБЦТС-ын Зуунмод сумын хэрэглэгчдэд үйлчлэх төв	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
21	Прокурор	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
22	Шүүх	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
23	ШШГА	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
24	Шүүхийн шинжилгээний алба	Сар бүрийн 25-нд	
25	ЦГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
26	ТЕГ-ын Төв аймаг дахь салбар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
27	УЦУОШГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
28	Стандарт хэмжилзүйн хэлтэс	Сар бүрийн 25-нд	
29	Мал эмнэлгийн газар	Сар бүрийн 25-нд	
30	МСҮТөв	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
31	ОНӨГазар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
32	Аудитын газар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
33	Зуунмод сумын Нэгдсэн үйлчилгээ олон нийттэй харилцах алба /нэг цэгийн үйлчилгээ/	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
34	26 сумын ЗДТГ	Сар бүрийн 25-нд	Сумын Эрүүл мэндийн төв
35	Эрүүл мэндийн газар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
36	Хаан банк-Зуунмод салбар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
37	Төрийн банк-Зуунмод салбар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн
38	Хас банк-Зуунмод салбар	Сар бүрийн 25-нд	ЭМГ-НЭМХ Т.Нямсүрэн